



## МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Метро бизнес төв, А блок 5 давхар  
Д.Сүхбаатарын гудамж-13  
Сүхбаатар дүүрэг, УБ 14201-0033  
Утас: 30 42 58, Факс: (976-11) 32 77 20  
Цахим хуудас: [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn)  
Цахим шуудан: [info@crc.gov.mn](mailto:info@crc.gov.mn)

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗАРТ

2020.07.27 № 01/1359

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлангийн аудит хийж менежментийн захидааар нийт гурван зөвлөмж, нэг албан шаардлагыг хүргүүлсэн.

Тус зөвлөмжийн хүрээнд Харилцаа Холбооны Зохицуулах хороо нь дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүнд:

#### 1. Зөвлөмж 1 ажлын хүрээнд:

Өгсөн зөвлөмж: Тайлант онд зөвлөх үйлчилгээ хийлгэж, гэрээний дагуу хүлээн авсан судалгааны ажлын тайлан, ажлын баримт зэргийг шууд зардлаар бүртгэсэн байна. Байгууллагын ажил үйлчилгээний хүрээнд судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээний ажлууд нь чухал үүрэг, ач холбогдолтой бөгөөд өгсөн зөвлөмжийн дагуу энэ төрлийн ажлыг төсвийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу холбогдох дансанд тусган бүртгэж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 87,6 сая төгрөгийн судалгаа шинжилгээний ажлыг холбогдох дансадад бүртгэн ажиллалаа.

#### 2. Зөвлөмж 2 ажлын хүрээнд:

Өгсөн зөвлөмж: Элэгдлийн зардлаараа анхны өртөгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 529,3 сая төгрөгийн анхны өртөгтэй 6 ширхэг автотээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоо арга хэмжээ аваагүй байна. Тус ажлын хүрээнд ашиглалтын хугацаа дуусаж элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлахад өртөг өндөртэй цаашид байгууллагын хэвийн ажиллагаанд ашиглах боломжгүй нийт 108.8 сая төгрөгийн өртөг бүхий Кия спорттэйж маркийн 21-28 УНЧ, Тоёота ланд крузер маркийн 00-98 УНН автомашинуудыг Хорооны хуралдааны 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 56 тоот тогтоол, ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 654 тоот “Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг тус тус үндэслэн ХХЗХ-ны даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/15 тоот тушаалын дагуу ажлын хэсэг байгуулан холбогдох хууль журмын дагуу

дуудлага худалдаа зохион байгуулж, худалдан борлуулсан орлогыг ТӨБЗГ-ын холбогдох дансанд төвлөрүүлэн ажиллалаа. Нийт 420,5 сая төгрөгийн өртөг бүхий 4 автомашиныг дахин үнэлж Хорооны өмч хамгаалах байнгын комиссын хурлын дүгнэлтийг үндэслэн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоох саналыг 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 01/1096 тоот албан бичгээр ТӨБЗГазарт хүргүүлсэн ба холбогдох шийдвэр 2020 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 403 тоот “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор баталгаажин ирсэн болно. Тус тогтоолд заасны дагуу нийт 420,5 сая төгрөгийг өртөг бүхий 4 автомашиныг 100,9 сая төгрөгөөр бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, 2020 оны 3 дугаар улиралд багтаан тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх, тайлагнах гэж заасны дагуу гүйцэтгэн ажиллана.

### **3. Зөвлөмж 3 ажлын хүрээнд:**

Өгсөн зөвлөмж: Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах ажлын хүрээнд бусад байгууллагын гадаад томилолтын зардалд нийт 26,1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үндэсний аудитын газрын өгсөн зөвлөмж болон Хорооны 2020 оны батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу ажиллаж дахин тухайн төрлийн зардлыг гаргаагүй ба бид цаашид холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах болно.

### **4. Зөвлөмж 4 ажлын хүрээнд:**

Албан шаардлага: Тайлант онд хорооны хурлын үйл ажиллагааны зардлыг 78,9 сая төгрөгөөр, хөтөлбөр арга хэмжээний зардлыг 34,4 сая төгрөгөөр нийт 113,3 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.

1. Цаашид батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй байж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, холбогдох арга хэмжээг авч, зөрчлийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор арилгаж, биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, ерөнхий нягтлан бодогч Н.Халиунаа нарт даалгав.
2. Дээрх зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах.

Дээрх хэтэрсэн зардлуудтай холбоотой хөтөлбөр арга хэмжээ, ажлууд нь 2018-2019 он дамжин хийгдсэний улмаас үүссэн бөгөөд тухайн тайлант оны хувьд хэтрэлтгүй ажилласан билээ. Өнөөдрийн байдлаар тус Хорооны 2020 оны үйл ажиллагаа батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа бөгөөд батлагдсан төсвийг хэтрүүлсэн аливаа асуудал үүсээгүй ба бид цаашид холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллана.

### **Бусад ажлын хүрээнд:**

ХХЗХ нь санхүүгийн бүртгэл тооцоонд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous 4.0 программыг, тусгай зөвшөөрлийн бүртгэл тооцоонд “Тусгай зөвшөөрлийн

биллинг" программыг тус тус ашигладаг ба эдгээр программууд нь уялдаа холбоо, бүртгэл талд учир дутагдалтай байсан тул боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай гэж үзэн "Байгууллагын санхүүгийн болон биллинг программ хангамжуудыг нэгтгэсэн шинэ систем хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ"-г авах зорилгоор холбогдох ажлыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд ЗУХАГ-ын дарга З.Эрдэнэчuluunaар ахлуулсан ажлын хэсэг байгуулж, ажлын даалгаврыг нарийвчлан гаргаж батлуулсан бөгөөд тендерт шалгаруулалтын үр дүнд Ординат ХХК-тай 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр "Байгууллагын санхүүгийн болон биллинг программ хангамжуудыг нэгтгэсэн шинэ систем хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулан ажиллаж байна. Тус ажлын явц 75% тай явж байгаа бөгөөд 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг шинээр нэвтрүүлж буй "Юникус" программ, холбогдох хууль тогтоомж, журам, зөвлөмжүүдийг тусган тайлагнан гаргалаа. Тусгай зөвшөөрлийн программд орлогыг бүртгэх, хүлээн зөвшөөрөх, санхүүгийн программд холбох, авлага, өглөг орлогоор бүртгэх ажлууд хийгдэж байна. Программ шинээр нэвтрүүлж буйтай холбоотойгоор тусгай зөвшөөрлийн журамд өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн гэрээ шинэчлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулан тусгах зэрэг ажлууд хийгдэх шаардлага зайлшгүй гарч байгаа ба холбогдох ажлууд хууль тогтоомжид нийцүүлэн хийгдэж байгаа болно. Тусгай зөвшөөрлийн авлага барагдуулах ажил тогтмол хийгдэж байгаа ба 2020 оны эхний 6 сарын байдлаар нийт 334,2 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажиллаад байна.

